



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/78

Баруун-Урт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны Конрактыг дүгнэх, 2022 оны гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ц.Алтансүх	- Орон нутгийн өмчийн газрын дарга
Гишүүд:	С.Ундрах	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	О.Саранчимэг	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Мөнхтуяа	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Н.Мөнхгэрэл	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Т.Хурцбаяр	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Ч.Батболд	- Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн Б.Даваадорж
дарга:

- Орон нутгийн өмчийн газрын
өмчийн бүртгэл хяналтын ахлах
мэргэжилтэн

2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2021 оны
Контрактыг дүгнэж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулах, 2022 оны гэрээ
байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Алтансүх)-т
даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ